

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 9 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 14 цаг 04 минутад эхэлж, 14 цаг 53 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Говьсүмбэр аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Говьсүмбэр аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Говьсүмбэр аймагт 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 16 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 9 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3 дугаар хавсралтаар батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 9</p>

		<p>иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Газрын тосны газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 03 дүгээр сарын 13-14-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Газрын тосны газар, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 27 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх</p>

		<p>хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 10 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 10 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагааны 2014 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн ТГ/141 тоот албан бичиг, захиалгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2014 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны 4 дүгээр сарын 11-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>
4	<p>Тогтоол хүчингүй болгох тухай /Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.1.6 дахь заалтыг баримтлан</p>

<p>даргад Д.Энхтуяаг нэр дэвшүүлсэн тогтоолыг хүчингүй болгох/</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар Дамдингийн Энхтуяад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гарган, нэр дэвшүүлсэн “Нэр дэвшүүлэх тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 21 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>2. Энэ тогтоолыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргал болон нэр дэвшигч Д.Энхтуяа нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ